



ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 9-Р САРЫН 30-НЫ БАЙДЛААР



Агуулга

1. Онцлох үйл явдал	3-4
2. Санхүүгийн үзүүлэлтүүд	5-12
3. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	13-14
4. Компанийн засаглал	15

Онцлох үйл явдал



2025 оны III улирал



2025 оны эхний хагас жилийн **ногдол ашиг**


18.0
нэгж хувьцаанд ₮

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-29, R-2025-30 тоот тогтоолоор ХасБанк ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөгийг хагас жилийн ногдол ашиг болгон хуваарилахаар хувьцаа эзэмшигчдэдээ санал болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд эчнээ санал хураалт хэлбэрээр зохион байгуулж байна.



Онцлох үйл явдал

2025 оны III улирал



Онцлох үйл явдал

2025 оны III улирал

ЗАЛУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ЗОРИУЛСАН ЗЭЭЛ


ХасБанк 35 хүртэлх насны залуу бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөтгөж, ашиг орлогоо нэмэгдүүлэн өгсөх шатанд нь хүч нэмэхийг зорьж, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг нь шийдэхэд зориулж “Залуу бизнес эрхлэгчийн зээл”-ийг санал болгож байна.




Шатлан буурах хүү
Зээлийн хугацааг 3 тэнцүү хувааж, хугацаа бүрд хүү 0.5 нэгжээр шатлан буурна.



Барьцааны хөнгөлөлт
50 сая хүртэл барьцаагүй, 100 сая хүртэл үл хөдлөх хөрөнгө шаардахгүй. 3-дагч этгээдийн барьцааг зөвшөөрнө.



SplendorPlus
Төлбөр тооцоонд төгс нийцсэн, нэр хүндийг илтгэх
Platinum card + Priority pass



 xacbank.mn

Бизнес тань шатлан өгсөж байхад зээлийн хүү зөрөөд бууна.

Цахим шилжилт

2025 оны III улирал

InstaPay

InstaXPay цахим хэтэвчийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, "Weekly Boost", "Наадмын амралтаа InstaXPay-тэй", "99% Anywhere" аянуудыг зарлаж өдөр тутмын худалдан авалтын төлбөрөө InstaXPay-р хийсэн харилцагчдадаа Reward бэлэглэлээ. Ингэснээр идэвхтэй хэрэглэгчийн тоо 16,700-д хүрч, нийт хандалтын тоо 70,000 боллоо.



ХасTeen+

7-17 насныханд зориулсан ХасTeen+ аппликейшний эхний хувилбарыг 5-р сард зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Тус аппликейшн нь өөрийн давтагдашгүй өнгө төрхийг бүтээж, өдөр тутмын санхүүгээ сонирхолтой, хялбар байдлаар бүрэн удирдах боломжийг хүүхэд залууст олгох юм.



Санхүүгийн үр дүн



2025 оны III улирал

Цэвэр ашиг	ROE	ХАС (Хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮124.9 тэрбум	21.4%	₮880.0	₮158.5*	20.0%	39.5%

Ашигт ажиллагаа

- 2025 оны III улиралд ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 39.0 тэрбум төгрөгт хүрч, өссөн дүнгээр цэвэр ашиг 124.9 тэрбум төгрөг буюу өмнөх жилийн мөн үеэс 3.0 хувиар буурсан байна. Тайлант хугацаанд заавал байлгах нөөцийн хэмжээ өссөн, төв банкны своп хэлцлийн хүү нэмэгдсэн зэрэг нь банкны ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.
- 2025 оны III улирлын байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 21.4 хувь, нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 158.5 төгрөг байна.

Баланс

- Нийт зээлийн багц 4,141 тэрбум төгрөгт хүрч, өмнөх улирлаас 1.9 хувиар буурсан бол оны эхнээс 12.0 хувиар өслөө.
- Иргэдийн банкны зээлийн багц оны эхнээс 7.9 хувиар өсөж 2,791 тэрбум төгрөгт хүрэхэд хэрэглээний болон бичил, ЖДБ зээлийн өсөлт нөлөөлжээ. Өмнөх улиралтай харьцуулахад цалингийн зээлийн багцын бууралт болон ипотекийн зээлийг МИК-д шилжүүлсэн зэрэг нь багц 4.4 хувь буурахад нөлөөлсөн байна.
- ХасЛизингийн санхүүгийн түрээс болон зээлийн багц 636 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 36.1 хувь, өмнөх улирлаас 4.0 хувиар өслөө. Шинэ болон дугаартай автомашины эрэлт өндөр байгаа нь ХасЛизингийн багц өсөхөд голлон нөлөөлсөн байна.
- Байгууллагын банкны зээлийн багц өмнөх улирлаас 3.7 хувиар, оны эхнээс 11.1 хувиар өсөж 715 тэрбумд төгрөгт хүрсэн байна.
- Чанаргүй зээлийн харьцаа 2.4 хувь байгаа нь банкны салбарын тэргүүлэх үзүүлэлт юм.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ өмнөх улирлаас 3.7 хувиар, оны эхнээс 3.6 хувиар өсөж 3,546 тэрбум төгрөгт, гадаад эх үүсвэрийн хэмжээ өмнөх улирлаас 2.9 хувиар, оны эхнээс 38.8 хувиар өсөж 623 сая ам.долларт тус тус хүрлээ.

Харьцаа үзүүлэлт

- 2025 оны III улирлын байдлаар Монголбанкнаас тогтоосон харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохистой хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 20.0 хувь буюу доод хэмжээг 7.5 нэгж хувиар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2025 оны 9 сарын 30-ний байдлаар 39.5 хувьтай байгаа нь зохистой харьцааг хангаж байна.


* Жилд шилжүүлсэн нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг

Санхүүгийн үзүүлэлтийн тренд

2025 оны III улирал

Цэвэр ашиг

Тэрбум төгрөг



Нийт актив

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг




Өөрийн хөрөнгийн өгөөж

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.




1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

Байвал зохих доод хэмжээ 12.5%



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

Байвал зохих доод хэмжээ 25.0%



Зээлийн үйл ажиллагаа



2025 оны III улирал

Нийт зээлийн тоо

221.8мянга ▼ -3.0% QoQ ▲ +17.0% YTD

Иргэдийн банк зээлийн тоо

216.4мянга

Байгууллагын банк зээлийн тоо

0.2мянга

ХасЛизинг с.түрээсийн тоо

5.1мянга

Онлайн зээлийн тоо

149.0мянга ▼ -3.4% QoQ ▲ +20.3% YTD

Зээлийн багц

Тэрбум төгрөг



Зээлийн багц бизнесийн сегментээр

Тэрбум төгрөг

■ 25-II ■ 25-III



- 2025 оны III улиралд ХасЛизингийн багц 4.0 хувиар буюу 24.7 тэрбум төгрөг, Байгууллагын банкны багц 3.7 хувиар буюу 25.6 тэрбум төгрөгөөр тус тус өслөө. Бизнесийн зээл болон автомашины санхүүгийн түрээсийн эрэлт эерэг нөлөө үзүүлжээ.
- Мөн хугацаанд цалингийн зээлийн бууралт болон ипотекийн зээлийг МИК-д шилжүүлсэн нь Иргэдийн банкны багц 4.4 хувиар буюу 129.9 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна

Дотоод эх үүсвэр

2025 оны III улирал



Нийт дансны тоо

1.5сая ▲ 1.4% QoQ ▲ 7.9% YTD

Харилцах дансны тоо

936.5 мянга

Хадгаламжийн дансны тоо


560.9 мянга

“Асуудалгүй” үйчилгээний хэрэглэгчийн тоо

65.2 мянга ▲ 11.3% QoQ ▲ 375.7% YTD

Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- 2025 оны III улиралд ХасБанкны харилцах дансны үлдэгдэл 793 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 8.1 хувь өссөн байна.
- Уламжлалт салбарын сувгийн үйлчилгээг үргэлжлүүлэхээс гадна дижитал, цахим суваг, төлбөр тооцоо, картын бүтээгдэхүүнийг сайжруулахад чиглэсэн хөгжүүлэлт, төслүүд дээр ач холбогдол өгч ажилсан ба үр дүнд нийт хадгаламж өмнөх улирлаас 2.4 хувиар өсөж 2,754 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Гадаад эх үүсвэр


2025 оны III улирал

2025 оны гуравдугаар улирлын байдлаар Хөгжлийн болон Олон улсын санхүүгийн байгууллагуудаас татсан нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 623 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд 2025 онд шинээр авсан EBRD (147.0 сая ам.доллар), AXB (50.0 сая ам.доллар), BlueOrchard (25.0 сая ам.доллар), Finnfund (10.0 сая ам.доллар), DWM (6.2 сая ам.доллар) болон Symbiotics (5.0 сая ам.доллар)-ын санхүүжилтүүд багтжээ.

Symbiotics болон BlueOrchard-ийн санхүүжилт гуравдугаар улиралд орж ирснээр нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл өмнөх улирлаас 2.9 хувиар, 2024 оны жилийн эцсээс 38.8 хувиар тус тус өслөө.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



III улиралд авсан гадаад эх үүсвэрүүд



\$25,000,000

Тайлант хугацаанд BlueOrchard байгууллагатай 35.0 сая ам.долларын гэрээ байгуулж 25.0 сая ам.долларыг татан төвлөрүүлээ.



\$5,000,000

Мөн урт хугацаанд хамтран ажиллаж буй Symbiotics байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж шинээр 5.0 сая ам.долларын гэрээ байгууллаа.

Хувьцааны мэдээлэл

2025 оны III улирал

ХасБанк ХК (ХАС)-ын хувьцааны үнэ 2025 оны 9 сарын 30-нд 888.0 төгрөгөөр хаагдсан нь оны эхнээс 6.5 хувь, IPO хийсэн үнээс 30.0 хувь өслөө. 2025 оны III улирлын байдлаар нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг 158.5 төгрөг байна.

ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг Монголбанкны холбогдох зөвшөөрлийн дагуу 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ХасБанк 2025 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1,417,521 ширхэг хувьцааг халаасалсан байна.


2025 оны эхний хагас жилийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 18.0 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар ТУЗ санал болгосон байна. Монголбанкны зөвшөөрөл болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (EGM)-ын санал хураалтын үр дүнд үндэслэн 2025 оны 10 дугаар сард ногдол ашиг тараагдахаар хүлээгдэж байна.

ХАС хувьцааны ханш, арилжааны хэмжээ



Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг



*Тус шийдвэрийг Монголбанкнаас зөвшөөрч, Банкны Дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсны дараагаар ногдол ашгийг тараах юм

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


2025 оны III улирал

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

20.0% Байвал зохих доод хэмжээ 12.5%


Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

39.5% Байвал зохих доод хэмжээ 25.0%



Түргэн борлогдох актив

Нийт 2,140.7 тэрбум төгрөг



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-2.3%	-6.2%	-1.7%	-2.0%	-4.9%	-0.6%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-3.3%	-9.1%	-2.0%	-3.3%	-5.7%	-1.4%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	52.9%	56.9%	41.7%	51.7%	46.3%	51.8%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.2%	1.2%	1.2%	1.2%	1.1%	1.1%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.9%	7.4%	7.9%	7.0%	6.8%	6.9%

	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.7%	1.7%	2.2%	1.7%	0.9%	1.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	2.9%	2.8%	0.0%	0.0%	0.0%	0.0%

	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал
Банкны холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.7%	1.7%	2.3%	1.8%	0.9%	1.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.5%	0.4%	0.3%	0.3%	0.4%	0.4%
Банкны бусад холбогдох этгээд	2.9%	2.8%	0.1%	0.0%	0.1%	0.1%

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон түүний дэргэдэх хорооны хурал

2025 оны III улирал



Шинээр баталсан:

1. Залилангийн нэсрэг журам

Нэмэлт, өөрчлөлт оруулсан:

1. ТУЗ-ийн нүйлажиллагааны журам
2. Дотоод аудитын дүрэм
3. Аудитын хорооны дүрэм

Шинэчлэн баталсан:

1. Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого



Монголбанк, Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хорооноос тус тус олгосон зөвшөөрлийн дагуу, ХасБанкны толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэж, нэгтгэлийг 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлснээр нэгтгэх ажиллагаа бүрэн дуусгавар болсон. Ингэснээр Банкны тухай хуульд заасан нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувь эзэмшлийн төвлөрөл 20%-иас хэтрэхгүй байх шаардлагыг хуулийн хугацаанаас даруй нэг жил гаруйн өмнө хангасан системийн нөлөө бүхий анхдагч банк боллоо.



☎ (976)-75771888-(888)

✉ investor-relations@xacbank.mn

🌐 <https://www.xacbank.mn>